



СУХЖСВМХ тээврийн хэрэгслийг асаах механизмыг түгжих тухай гэрээ

2015 оны 3-сарын 27-нд шинэчлэв

Согтууруулах ундаа хэрэглэж жодоолохоос сэргийлэх Виржиниа мужийн хөтөлбөр (СУХЖСХВМ)
Аюулгүй, эрүүл жолоодоход таныг хөтөлнө

Би дараах нөхцөл болзлыг чанд дагаж биелүүлэх ёстой болохоо ойлгож, хүлээн зөвшөөрч байна.

1. Хэрэв намайг согтууруулах ундаа уусан үедээ тээврийн хэрэгсэл анхны удаа жолоодсон гэж тогтоовол би аливаа тээврийн хэрэгсэлд асаах механизмыг түгжих төхөөрөмж суурилуулах ёстой. Хэрэв суурилуулаагүй бол миний бие асаах механизмыг түгжих шаардлагыг дахин биелүүлэхэд хүргэх болно.
2. Хэрэв намайг согтууруулах ундаа уусан үедээ тээврийн хэрэгсэл хоёр дахь удаа жолоодсон гэж тогтоовол би аливаа тээврийн хэрэгсэлд асаах механизмыг түгжих төхөөрөмж суурилуулах ёстой.
3. Хэрэв би асаах механизмыг түгжих төхөөрөмж аливаа тээврийн хэрэгсэлд суурилуулсан үедээ шинэ тээврийн хэрэгслийг бүртгүүлэх эсвэл өмчлөх гэрчилгээ авбал СУХЖСХ-т ажлын 24 цаг дотор мэдэгдэж, хуанлийн 10 хоногийн дотор механизмыг түгжих төхөөрөмжийг суурилуулах ёстой. Хэрэв би согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас анх удаа асаах механизмыг түгжих шаардлагыг биелүүлж байгаа бол зөвхөн шинээр нэмэгдсэн тээврийг хэрэгслийг жолоодохоор зорьж байгаа бол СУХЖСХ-т мэдэгдэх хэрэгтэй. Энэ шаардлагыг биелүүлээгүй бол миний бие асаах механизмыг түгжих шаардлагыг дахин биелүүлэхэд хүргэх болно.
4. Хэрэв би тээврийн хэрэгсэл өмчилдөггүй бөгөөд тус шаардлагыг биелүүлэхийн тулд өөр хүний тээврийн хэрэгсэлд төхөөрөмж суурилуулахаар шийдвэл өмчлөгч этгээд “Асаах механизмыг түгжих төхөөрөмжийг суурилуулахыг зөвшөөрөх маягтад” гарын үсэг зурж, нотариатаар баталгаажуулах ёстой болохыг ойлгож байна.
5. Хэрэв шүүх асаах механизмыг түгжих төхөөрөмж суурилуулахгүйгээр ажил олгогчийн тээврийн хэрэгслийг жолоодохыг надад зөвшөөрвөл би түгжих шаардлагыг биелүүлэхийн тулд хувийн тээврийн хэрэгсэлдээ түгжих төхөөрөмж суурилуулах шаардлагатай болохыг ойлгож байна.
6. DC266 Асаах механизмыг түгжих тухай тушаалд заасан хүчин төгөлдөр өдрөөс эхлэн 30 хоногийн дотор түгжих төхөөрөмжийг суурилуулах ёстой бөгөөд би Виржиниа мужийн 18.2-270.1 хуулийн дагуу доод тал нь 30 хоног тутам Виржиниа мужийн зөвшөөрөлтэй түгжих төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар тохиргоо хийлгэх ёстой болохыг ойлгож байна. Эдгээр шаардлагыг биелүүлэхгүй бол шаардлага зөрчсөн гэсэн үндэслэлээр миний хэргийг шүүхэд буцааж болзошгүй.
7. Хэрэв түгжих төхөөрөмж рүү 1,5 литр үлээх миний чадварт сөргөөр нөлөөлөх өвчин эмгэгтэй бол эмчлэх тусгай зөвшөөрөлтэй уушигны эмч эсвэл миний өвчнөөр мэргэшсэн мэргэжилтнээс тодорхойлолт авч, орон нутгийн СУХЖСХ-т өгөх ёстой. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжгүй үйлчлүүлэгчийг тухайн хэрэгт үндэслэн тодорхойлно.
8. Хэрэв зөвхөн сүүлд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоодсоны улмаас түдгэлзүүлсэн бол Виржиниа мужийн тээврийн хэрэгслийн газраас (ТХГ) үнэмлэхээ авахад буруутай болохыг тогтоосон өдрөөс эхлэн 60 хоног байгаа болохыг ойлгож байна. 60 хоногийн дотор аваагүй бол миний бие асаах механизмыг түгжих шаардлагыг дахин биелүүлэхэд хүрэх болно.

9. Хэрэв согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон хэргээс өөр бусад шалтгаанаар миний үнэмлэхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон эсвэл жолоодох эрхгүй болгосон бол миний хязгаарлалттай, хүчин төгөлдөр үнэмлэх авах өдрөөс өмнөх асаах механизмыг түгжих хугацаанаас хасахгүй болохыг би ойлгож байна.
10. Хэрэв би ТХГ-ын захиргааны түгжих шаардлагыг биелүүлэхий оролдвол би бүртгүүлснээс хойш 60 хоногийн дотор ТХГ-аас үнэмлэхээ авах ёстой бөгөөд эс бөгөөс миний хэргийг хаах болохыг ойлгож байна.
11. Цусан дахь согтууруулах ундааны агууламж (ЦДСУА) 0,02% эсвэл түүнээс илүү хэмжээтэй бүртгэгдсэн, дахин өгөх шинжилгээг алгассан эсвэл тухайн этгээд шинжилгээ өгөхдөө ямар нэг байдлаар хэн болохоо нуусан тохиолдлыг зөрчил гэж үзэх болохыг би ойлгож байна. Хэрэв миний ЦДСУА 0,02% байснаас 15 минутын дотор ЦДСУА 0,000% болох эсвэл дахин өгөх шинжилгээг алгассан бол түгжих тохиолдлыг зөрчил гэж үзэхгүй байж болно.
12. Миний түгжих төхөөрөмжийн сүүлийн тохиргоог түгжих шаардлагыг биелүүлсэн өдөр эсвэл тэд өдрийн дараа хийх бөгөөд биелүүлсний дараа би орон нутгийн СУХЖСХ-тэй холбоо барих ёстой болохыг би ойлгож байна.
13. Хэрэв шүүхээс согтууруулах ундаатай холбоотой зөрчил гаргахгүй доод тал нь дараалан зургаан сар өнгөрөхөөс өмнө миний түгжих төхөөрөмжийг салгах тухай шийдвэр гаргавал орон нутгийн СУХЖСХ төхөөрөмжийг салгах боловч би Виржиниа мужийн 18.2-270.1 хуулийн дагуу энэ шаардлагыг биелүүлэх шаардлагатай бөгөөд түгжих шаардлагыг дахин тавих болно гэдгийг би ойлгож байна.
14. Түгжих төхөөрөмжтэй холбоотой бүх үйлдлийг би ганцаараа хариуцах болохыг би ойлгож байна.
15. Согтууруулах ундаа хэрэглэж жолоодохоос сэргийлэх Виржиниа мужийн хөтөлбөрийн (СУХЖСВМХ) коммиссоос зөвшөөрөөгүй бол би түжих төхөөрөмжийг суурилуулсны дараа борлуулагчийг сольж болохгүй.
16. Би СУХЖС хөтөлбөрийн ажиглалтын бүх зардлыг хариуцах, мөн түгжихтэй холбоотой зөрчил гаргасны улмаас түгжих шаардлагыг сунгасан бол нэмэлт төлбөр хураамж гарч болохыг би ойлгож байна. Бүх төлбөр хураамжийг төлтөл миний хэргийг хаахгүй болно.
17. Шүүхээс тушаасан бөгөөд ТХГ-ын асаах механизмыг түгжих шаардлагыг амжилттай биелүүлтэл эдгээр нөхцөл болзол үйлчилнэ. Асаах механизмыг түгжихтэй холбоотой бүх шаардлагыг биелүүлээгүй бол миний хэргийг шүүх рүү буцааж эсвэл асаах механизмыг түгжих хөтөлбөрөөс хасаж болно. Би эдгээр нөхцөлийн хувийг хүлээн авсан болохоо хүлээн зөвшөөрч байна.
18. Би vasap.virginia.gov хаягаар Асаах механизмыг түгжихтэй холбоотой видео бичлэгийг үзэх шаардлагатай. Хэрэв танд интернэтэд холбогдох боломж байхгүй бол та энэ тухай СУХЖСХ-т мэдэгдэх ёстой. Та видео бичлэгийг үзэж байхдаа энэ гэрээний хувийг авсан байвал зохино. Энэ баримт бичгийн хувь онлайн хэлбэрээр дараах вэбсайтын хаягт бий.

(Үйлчлүүлэгчийн нэр)

(Огноо)

(Үйлчлүүлэгчийн гарын үсэг)

(Хэрэг хариуцсан менежер/Техникчийн гарын үсэг)